



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 54.5 сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газрын санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит үйлдвэрийн газар нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлтээр 90.8 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээ авсан байх тул үйлдвэрийн газрын захирал (Б.Ичинхорлоо)-д албан даалгаврын биелэлтийг 100 хувь хангаж ажиллах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2. Ашиглалтгүй байгаа 2018 онд худалдан авсан 54.5 сая төгрөгийн балансын үнэ бүхий 31-20 УББ Форланд маркийн тээврийн хэрэгслийг засварлаж төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах;

2.3. Нэг ба түүнээс дээш жилийн насжилттай авлагыг барагдуулах арга хэмжээг хууль, хяналтын байгууллагатай хамтран ажиллаж эрчимжүүлэх;

2.4. Захиралтай байгуулсан Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.2.11-т заасны дагуу барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж, компанийн эд хөрөнгийн эзэмшилт, ашиглалт хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоод хяналтыг удирдан зохион байгуулж, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтын асуудалд хяналт тавьж ажиллах;

2.5. Тендерийн явц, гүйцэтгэлийн үр дүн, гэрээг Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу мэдээллийн санд тухай бүр оруулж хэвшүүлэх;

2.6.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.


4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
17 дугаар тогтоолын хавсралт



“Дипломат байгууллагын үйлчилгээг эрхлэх газар” төрийн өмчит
үйлдвэрийн газарт хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)	Зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалт
1	Хөрөнгийн бүрэн бүтэн байдал, эзэмшилт, ашиглалтад хяналт тавьж ажиллаагүй	54.5	Тээврийн хэрэгслийг засварлахад шаардагдах сэлбэг материалын тооцоо судалгаа хийж, үйлдвэрийн газрын ирэх жилийн төлөвлөгөөнд тусгах замаар хөрөнгийн ашиглалтыг сайжруулах арга хэмжээ авах
2	Худалдан авах ажиллагааг хууль тогтоомж, холбогдох журмыг зөрчин зохион байгуулсан	-	ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.4, 47.7, 47.8, 2010 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 212 дугаар тогтоолоор баталсан “Үнэлгээний хорооны зохион байгуулалт, үйл ажиллагаа, урамшууллыг зохицуулах журам”-ын 4.2, 3.5.4, 2.2 дахь заалтуудыг дагаж мөрдөх, Цаашид Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 103 дугаар тушаалаар батлагдсан журмыг дагаж мөрдөх
Нийт хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын дүн		54.5 (Тавин дөрвөн сая таван зуун мянган төгрөг)	